



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 25 өдөр

Дугаар А/595

Хэрлэн сум

Ерөнхий сайдын айлчлалд
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.5, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ерөнхий сайд болон бусад албаны хүмүүс 2022 оны 11 дүгээр сарын 17-оос 2022 оны 11 дүгээр сарын 20-ны хооронд Хэнтий аймагт ажилласантай холбогдуулан 12.744.000 (арван хоёр сая долоон зуун дөчин дөрвөн мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын нөөц сангийн урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2022 оны 05 дүгээр сарын 05-ны дугаар захирамжийн хавсралт

Шаардагдах зардлын тооцоо

Д/д	Зардлын төрөл	Хүний тоо	Нэг өдрийн үнэ /₮/	Нийт хоног	Нийт
1	Хоол	14	75,000	3	3,150,000
		17	59,029	4	4,014,000
Нийт					7,164,000
2	Буудлын хөлс	1	140,000	2	280,000
		5	110,000	2	1,100,000
		5	70,000	4	1,400,000
		20	70,000	2	2,800,000
Нийт					5,580,000
Нийт		31		12,744,000	